



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

"Олон улсын худалдаа логистикийн төв" ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2025/050/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга Ч.Болд
	Утас: 7000-77348 Цахим хаяг: bold@audit.gov.mn
	Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер Я.Алтанцэцэг Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegva@audit.gov.mn
	Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК Захирал А.Сарангэрэл Утас: 99884842 Цахим хаяг: gereltekhburtgelaudit06@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.03.14 № 01/328
танай _____-ны № _____-г

ОЛОН УЛСЫН ХУДАЛДАА
ЛОГИСТИКИЙН ТӨВ ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
С.БЯМБАСҮРЭН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Олон улсын худалдаа, логистикийн төв ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 1,054.3 сая төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Газрын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Газрын дуудлага худалдааг зохион байгуулаагүйгээс 2015 онд үүссэн Нийслэлийн төрийн санд өгөх 433.5 сая төгрөгийн он дамжсан өглөгтэй байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд нийт 3,314.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөснөөс 253.9 сая төгрөг буюу 108.3 хувиар давж биелсэн, нийт зардал 3,503.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 442.7 сая төгрөг буюу 114.5 хувиар хэтрүүлэн зарцуулсан байна.

Бусад асуудал

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр нийт 5 хөтөлбөрийн 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 9 арга хэмжээ 50 хувийн хэрэгжилттэй, бусад арга хэмжээг хэрэгжүүлээгүй гэж тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	60,636,254.66	260,161,397.64
1.1.2	Дансны авлага	480,270,947.69	634,059,215.44
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	104,531.47	2,429,790.46
1.1.4	Бусад авлага	-	34,972,716.00
1.1.6	Бараа материал	99,389,119.88	124,084,365.98
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	344,657,454.55	331,333,454.55
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	96,747,389.59	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,081,805,697.84	1,387,040,940.07
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	12,912,345,285.15	12,233,163,775.15
1.2.2	Биет бус хөрөнгө	46,528,608,000.00	46,528,608,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	59,440,953,285.15	58,761,771,775.15
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	60,522,758,982.99	60,148,812,715.22
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	893,567,899.56	500,955,453.10
2.1.1.3	Татварын өр	143,349,171.94	250,898,581.63
2.1.1.4	НДШ – ийн өглөг	10,042,342.72	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	21,958,131.11	51,997,386.69
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	186,441,275.05	263,395,275.05
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,255,358,820.38	1,069,805,839.76
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,255,358,820.38	1,069,805,839.76
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	29,521,070,796.00	29,521,070,796.00
2.3.2	хувийн	0.00	0.00
2.3.3	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	16,005,129.80	16,005,129.80
2.3.4	Эздийн өмчийн бусад хэсэг	33,288,739,667.00	33,288,739,667.00
2.3.5	Хуримтлагдсан ашиг	(3,558,415,430.19)	(3,746,808,717.34)
2.3.6	Эздийн өмчийн дүн	59,267,400,162.61	59,079,006,875.46
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	60,522,758,982.99	60,148,812,715.22

1.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,469,707,784.83	3,306,987,358.89
2	Борлуулалтын өртөг	-	53,788.74
3	Нийт ашиг(алдагдал)	2,469,707,784.83	3,306,933,570.15
5	Хүүгийн орлого	269,238.37	285,154.67
6	Бусад орлого	-	7,714,545.45
7	Борлуулалт, маркетингийн зардал	1,310,712,000.12	1,535,271,052.71
8	Ерөнхий ба удирдлагын зардал	1,703,596,432.01	1,922,067,562.77
9	Бусад зардал	8,636,738.09	45,969,510.47
10	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(66,041,089.67)	-
11	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(619,009,236.69)	(188,374,855.68)
12	Орлогын татварын зардал	0.00	18,431.47
13	Татварын дараах ашиг (алдагдал)	(619,009,236.69)	(188,393,287.15)
14	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(619,009,236.69)	(188,393,287.15)
15	Орлогын нийт дүн	(619,009,236.69)	(188,393,287.15)

1.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	29,521,070,796.00	16,005,129.80	(2,939,406,193.50)	59,886,409,399.30
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	29,521,070,796.00	16,005,129.80	(2,939,406,193.50)	59,886,409,399.30
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(619,009,236.69)	(619,009,236.69)
7	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	29,521,070,796.00	16,005,129.80	(3,558,415,430.19)	59,267,400,162.61
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	29,521,070,796.00	16,005,129.80	(3,558,415,430.19)	59,267,400,162.61
10	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(188,393,287.15)	(188,393,287.15)
11	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	16,005,129.80	-	16,005,129.80
13	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	29,521,070,796.00	16,005,129.80	(3,746,808,717.34)	59,079,006,875.46

1.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,717,124,675.33	3,658,973,807.48
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,693,420,150.83	3,622,804,441.65
	Буцаан авсан албан татвар	23,704,524.50	28,454,820.38
	Бусад мөнгөн орлого	-	7,714,545.45
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(2,612,103,697.83)	(3,456,349,024.06)
	Ажиллагчдад төлсөн	(745,414,950.75)	(970,449,868.71)
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(205,532,514.27)	(284,933,356.68)
	Бараа материал худалдан авахад төлсөн	(1,430,130,182.72)	(1,779,992,143.42)
	Ашиглалтын зардалд төлсөн	-	(11,338,000.00)
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(4,304,318.18)	(23,399,372.73)
	Татварын байгууллагад төлсөн	(164,271,664.36)	(245,521,933.20)
	Даатгалын төлбөрт төлсөн	(663,300.00)	-
	Бусад мөнгөн зарлага	(61,786,767.55)	(140,732,780.79)
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	105,020,977.50	202,624,783.42
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	269,238.37	285,154.67
	Хүлээн авсан хүүгийн орлого	269,238.37	285,164.67
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(105,250,359.55)	(3,366,363.64)
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(105,250,359.55)	(3,366,363.64)
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(104,981,121.18)	(3,081,208.97)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	39,856.32	199,525,142.98
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	60,596,398.34	60,636,254.66
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	60,636,254.66	260,161,397.64

1.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2023 оны гүйцэтгэл	2024 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	2	3	4	5	6	7
А	Авто зогсоолын түрээс	1,594,497,931.5	2,100,000,000.0	2,205,350,001.2	105,350,001.2	105.0
1	Контейнер байрлуулсаны орлого	14,036,363.6	5,000,000.0	9,109,090.9	4,109,090.9	182.2
2	Авто зогсоол ашиглалтын орлого	151,936,235.9	160,000,000.0	165,514,765.1	5,514,765.1	103.4
3	Өмчлөлтэй зогсоолын газрын төлбөр	24,523,194.5		23,522,189.3	23,522,189.3	
Б	Сурталчилгааны самбарын түрээс	4,300,000.0	24,000,000.0	1,276,363.6	(22,723,636.4)	5.3
1	Зөөврийн барилгын газар ашиглалт	264,833,991.3	270,000,000.0	350,475,171.6	80,475,171.6	129.8
2	Цахилгаан орлого	170,857,672.1	180,000,000.0	228,494,059.0	48,494,059.0	126.9
3	Орох хаалганы тасалбарын орлого	237,527,805.1	245,000,000.0	279,831,072.3	34,831,072.3	114.2
В	Чанга яригч узель	297,318.2	396,000.0		(396,000.0)	-
1	Дугаартай автомашин болон цахимаар авто машин борлуулах					-
2	Дугуй түгжигчийн орлого	2,870,909.1	6,000,000.0	11,398,129.9	5,398,129.9	190.0
3	Бусад түрээсийн орлого (АТМ, Киоск)	4,295,602.0	4,400,000.0	32,016,516.0	27,616,516.0	727.6
4	Чирэгч машины орлого					-
5	Авто машин түр журамлах хашаа					-
6	Цахим хуудаст баннер байршуулах 2 төрөл		66,000,000.0		(66,000,000.0)	-
7	Үйл ажиллагааны бус орлого			7,999,700.1	7,999,700.1	
Нийт дүн		2,469,977,023.2	3,060,796,000.0	3,314,987,059.0	254,191,059.0	1,684.5
1	Цалин	921,241,833.8	1,211,616,000.0	1,210,537,228.0	1,078,772.0	99.9
2	НДШ	112,249,892.6	151,452,000.0	143,503,375.0	7,948,625.0	94.8
3	Албан татвар хураамж /Машины татвар бусад/	97,500.0		1,151,863.5	(1,151,863.5)	
4	Ашиглалтын зардал	273,315,222.7	314,840,000.0	378,502,962.1	(63,662,962.1)	120.2
5	Бичиг хэрэг	15,445,659.0	9,000,000.0	11,753,777.3	(2,753,777.3)	130.6
6	Шатахуун	26,606,808.4	18,000,000.0	21,926,563.0	(3,926,563.0)	121.8
7	Даатгалын зардал	663,300.0				-
8	Сэлбэг хэрэгсэл тээвэр	2,153,000.0	5,700,000.0	10,955,454.6	(5,255,454.6)	192.2
9	Шуудан холбоо	5,643,102.4	33,000,000.0	43,926,296.1	(10,926,296.1)	133.1
10	Сургалтын зардал	5,190,000.0	20,000,000.0	4,668,181.8	15,331,818.2	23.3
11	Түрээсийн зардал	31,250,000.0	-	34,881,600.0	(34,881,600.0)	
12	Хангамжийн зардал	147,528,029.4	38,000,000.0	147,215,744.4	(109,215,744.4)	387.4
13	Хөдөлмөр хамгааллын зардал	1,564,129.3	25,000,000.0	28,986,590.9	(3,986,590.9)	115.9
14	Зар сурталчилгааны зардал	26,722,272.7	30,000,000.0	37,125,563.6	(7,125,563.6)	123.8
15	Томилолтын зардал	-	50,000,000.0	11,218,000.0	38,782,000.0	22.4
16	Засвар үйлчилгээний зардал	103,234,630.9	55,000,000.0	178,519,442.8	(123,519,442.8)	324.6
17	Элэгдлийн зардал	836,472,905.2	840,000,000.0	837,623,985.6	2,376,014.4	99.7
18	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	80,605,454.6	80,000,000.0	74,282,909.1	5,717,090.9	92.9
19	Газрын төлбөр	160,097,871.0	147,000,000.0	163,978,748.0	(16,978,748.0)	111.6
20	Бусад зардал	330,267,909.8	3,000,000.0	116,652,550.2	(113,652,550.2)	3,888.4
21	Үйл ажиллагааны бус зардал	8,636,738.1	29,000,000.0	45,897,290.3	(16,897,290.3)	158.3
Нийт дүн		3,088,986,259.9	3,060,608,000.0	3,503,308,126.0	(442,700,126.0)	114.5
Борлуулсан бүтээгдхүүний өрөг		-	-	53,788.7	(53,788.7)	

1	Татварын өмнөх ашиг/алдагдал	(619,009,236.7)	188,000.0	(188,374,855.7)	(188,509,066.9)	(100,270.8)
2	Орлогын албан татвар	-	18,800.0	18,431.5	-	98.0
3	Цэвэр ашиг/алдагдал	(619,009,236.7)	169,200.0	(188,393,287.2)	(188,509,066.9)	(111,412.0)

2. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 15,448,364.3 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Худалдан авсан хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайланд тайлагнаагүй	1	58,382.5	-	-	1	58,382.5	1	58,382.5	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дотоодын шилжилт хөдөлгөөнийг худалдан авснаар тайлагнасан	1	15,389,981.8	-	-	1	15,389,981.8	1	15,389,981.8	-	-	-	-
Дүн	1	15,448,364.3	-	-	1	15,448,364.3	1	15,448,364.3	-	-	-	-

Аудитаар нийт 1,054,285.2 мянган төгрөгийн 5 зөрчил² илэрснээс, 714.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 722,237.1 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгч, 331,333.4 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албангуш аалтны тоо	Тоо	Дүн
Байгууллагын нэр дээр бүртгэлтэй хөрөнгийн шилжилт, хөдөлгөөнийг хийж, бүртгэлд тусгаагүй	1	714.7	1	714.7	-	-	-	-	-	-	-	-
Урьдчилж төлсөн зардал, тооцоо дансанд бүртгэсэн ажил 2015 онд үүссэн, арга хэмжээ аваагүй	1	331,333.4	-	-	-	-	1	331,333.4	-	-	-	-
Өглөгийн тооцоо хийж,	1	444,240.4	-	-	1	444,240.4	-	-	-	-	-	-

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

баталгаажуула агүй, он дамжсан авлагыг шийдвэрлээгүй												
Авлагын тооцоо хийж, баталгаажуулаагүй, он дамжсан авлагыг шийдвэрлээгүй	1	277,996.7	-	-	1	277,996.7	-	-	-	-	-	-
Элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийг хоблогдох байгууллагад уламжлан шийдвэрлээгүй	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	5	1,054,285.2	1	714.7	2	722,237.1	2	331,333.4	-	-	-	-

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 3,445,732.7 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 4 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг мэдээлээгүй, хугацаа хоцроосон	1	3,380,681.5	-	-	1	3,380,681.5	-	-
Дүн	1	3,380,681.5	-	-	1	3,380,681.5	-	-
Төрийн хэмнэлтийн хуультай холбоотой зөрчил								
Хөрөнгийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй олж бэлтгэсэн	1	88,672.0	-	-	-	-	1	88,672.0
Дүн	1	88,672.0	-	-	-	-	1	88,672.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулаагүй	1	-	-	-	1	-	-	-
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гаргасан боловч хууль журамд нийцүүлэн зохион байгуулж гүйцэтгээгүй	1	-	-	-	-	-	1	-
Зорилтот түвшний төлөвлөгөөг оновчтой зөв төлөвлөөгүйгээс 3 орлогны төлөвлөгөө тасарч, зардлууд хэтэрсэн	1	89,119.6	-	-	-	-	1	89,119.6
Ахмадуудад холбогдох хуульд заасан дэмжлэг үзүүлээгүй	1	-	-	-	-	-	1	-
Дүн	4	89,119.6	-	-	1	-	3	89,119.6
Нийт дүн	6	3,558,473.1	-	-	2	3,380,681.5	4	177,791.6